



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар ДАА-2019/17/ СТА-ТЗ-84/124 Зуунмод

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төв аймгийн Сэргэлэн сумын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн хариуцлагын гэрээгээр Ноён тохой ХХК, Эрдэнэ дорно ХХК -аас бэлнээр 10,000.0 мянган төгрөг авч баяр наадмын зардлаар тайлагнасан боловч зарцуулалтын тайланг ирүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 "тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 16 дугаар зүйлийн 16.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 -д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", МУЕА-ын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12 бүлгийн аудит хийх үе шатны 12.11-д аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг залруулах боломж байгаа эсэхийг эхэлж шийдвэрлэх бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийн шинж байдлаас нь хамааран дараах шийдвэрүүдийн аль нэг хэлбэрээр эцэслэн шийдвэрлэж баримтжуулан баталгаажуулна. гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх 10,000.0 мянган төгрөгийн баяр наадмын тайланг гаргаж 2019.06.01-ны дотор Төв аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэргэлэн сумын засаг дарга Э.Энхбаяр, орлогч дарга Г.Сүхбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ӨГСӨН²:

Ц.ХИШИГЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА

Э.ЭНХБАЯР

АХЛАХ АУДИТОР

Ц.БАЗАРСАД

ОРЛОГЧ ДАРГА

Г.СҮХБААТАР

² Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.